



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/31-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорнод аймаг 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: <a href="mailto:Bolortuulb@audit.gov.mn">Bolortuulb@audit.gov.mn</a> Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: <a href="mailto:Tsengelmaav@audit.gov.mn">Tsengelmaav@audit.gov.mn</a> Аудитор: М.Ухаанбилэг Утас: 70584207 Цахим хаяг: <a href="mailto:Ukhaanbilegm@audit.gov.mn">Ukhaanbilegm@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
Менежментийн захидал .....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	123
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	124
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	145
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	166
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	167





## 2.1. Оршил

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Д.Оюунчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэг нь “Инээд баясал, итгэл хайраар дүүрэн орчин бүрдүүлж, эрүүл чийрэг, сэргэлэн цовоо, зөв хүмүүжилтэй зөв монгол хүүхдийг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг хүрээнд ажиллаж байна.

Тайлант онд “Хичээл сургалтын үйл ажиллагааг чанартай бэлтгэн, үр дүнтэй хэрэгжүүлэх, багш ажилтны тасралтгүй хөгжлийг ханган, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллана.” гэсэн зорилттой ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 11 цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд АСОЛУОС программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 315,162.6 мянган төгрөгөөс тооцон 6,303.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,629.5 мянган төгрөгөөр тооцсон болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,606.2 мянган төгрөгөөр буюу 0,5 хувиар өссөн байна. Материаллаг хэмжээний өөрчлөлт орсон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	36,148.5	38,677.4	2,528.9
Үндсэн хөрөнгө	1,523,095.7	1,560,002.1	36,906.4
Элэгдэл	-116,317.4	-149,146.5	-32,829.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,442,926.8</b>	<b>1,449,533.0</b>	<b>6,606.2</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,442,926.8	1,449,533.0	6,606.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,442,926.8</b>	<b>1,449,533.0</b>	<b>6,606.2</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өмнө оноос өссөн нь бусад хангамжийн материалын 2,528.9 мянган төгрөгийн материалын үлдэгдлээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. Хэрлэн сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 37,173.9 мянган төгрөгийн хашаа, хүлэмж, тоног төхөөрөмжүүд болон өөрийн хөрөнгөөр 280,5 мянган төгрөгийн программ хангамжийн сайжруулалтын дүнгээр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо өссөн нь тайлант үеийн үр дүн хөрөнгө оруулалтын дүнгээр өссөнөөс шалтгаалсан байна.

**2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	0	247.5	-247.5	100
<b>Нийт дүн</b>	<b>0</b>	<b>247.5</b>	<b>-247.5</b>	<b>100</b>

Цэцэрлэг нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 298,509.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 283,509.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 297,637.2 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас урсгал засварт нэмж хуваарилсан 1,500.0 мянган төгрөг, тендерийн материал борлуулсны орлого 247,5 мянган төгрөг, нийт 1,747.5 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлсэн байна.

Үүнээс урсгал засварт 1,500.0 мянган төгрөгийг, бичиг хэрэгт 217.5 мянган төгрөгийг, ном хэвлэлд 30.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14,885.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,666.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,907.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 644,7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 667.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 12,551.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 644,7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 11,907.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тендерийн багцад ороогүй бүтээгдэхүүн авсан нь тендерийн баримт бичигтэй нийцэхгүй байна. Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй, татварын ебаримт программд 11,6 сая төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал бэлтгэн нийлүүлэгчээр сонгон шалгарсан хуулийн этгээдүүд бараа нийлүүлэх тендерийн үнийг баримталж ажиллаагүй, тендерт ирүүлсэн үнээр нийлүүлэхээр гэрээ байгуулагдсан ч цаг үеийн байдлаас шалтгаалж үнээ нэмж нийлүүлсэн тохиолдол илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл “Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох” хэсгийн 41.1.2- дахь заалтад “энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх.” мөн “хүүхдийн хоол хөтөлбөрийн хүрээнд худалдан авах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ”-ний 9-д “зах зээлийн үнэ харгалзахгүй тендерийн баримт болох нийлүүлэлтийн хуваарьт заагдсан үнээр жилийн хугацаанд нийлүүлнэ,..” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 667.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Ебаримтад бүртгэлгүй худалдан авалт хийж байгаад зөвлөмж өгсөн нь тайланд онд 76,7 хувийн биелэлттэй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Бичиг хэргийн материалын хөдөлгөөн өөрчлөлтийг хангамжийн бараа материалын ангиллаар бүртгэн, тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавартай нийцэхгүй байна.

**1.2. Эрсдэл:**

Тайлан буруу илэрхийлэгдсэнээс хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөгдөх.

**1.3. Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны заавар мөрдөж ажиллах

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:**

Тайлант онд хүүхдийн хоолны материал бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа ирүүлсэн материалуудыг үнэлсэн баримт байхгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаалаар батлагдсан Тендер үнэлэх заавар журамд нийцэхгүй байна.

**2.2. Эрсдэл:**

Худалдан авалтын шийдвэр буруу гарах.

**2.3. Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаалаар Тендер үнэлэх зааврыг мөрдөж ажиллах

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**



Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөг/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,148,539.39	38,677,457.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,148,539.39	38,677,457.37
351	Түүхий эд материал	00.00	00.00
354	Хангамжийн материал	36,148,539.39	38,677,457.37
35410	Бичиг хэргийн материал	1,019,500.00	1,019,500.00
35420	Аж ахуйн материал	46,600.00	61,600.00
35470	Бусад хангамжийн материал	35,082,439.39	37,596,357.37
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,406,778,347.17	1,410,855,626.41
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,406,778,347.17	1,410,855,626.41
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	1,331,723,347.17	1,335,575,126.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,381,377,599.00	1,412,479,528.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-71,111,111.20	-97,432,579.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,118,756.50	33,593,756.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,323,127.81	-28,576,206.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,297,382.20	25,297,382.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,285,149.41	-19,245,352.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,480,000.00	12,529,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,831,002.11	-3,070,401.95
393	Биет бус хөрөнгө	75,055,000.00	75,280,500.00
39301	Програм хангамж	822,000.00	1,102,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-767,000.00	-822,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	75,000,000.00	75,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,442,926,886.56	1,449,533,083.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,442,926,886.56	1,449,533,083.78
51	Засгийн газрын хувь оролцоо	1,442,926,886.56	1,449,533,083.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,445,232.20	122,445,232.20
51101	Өмч: - төрийн	122,445,232.20	122,445,232.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,219,104,055.36	1,225,710,252.58
51210	Өмнөх үеийн үр дүн	1,219,104,055.36	1,219,104,055.36
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,606,197.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	101,377,599.00	101,377,599.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,442,926,886.56	1,449,533,083.78

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөг/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	286,102,600.00	338,085,732.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
110	Орлогын албан татвар	00.00	00.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	00.00	00.00

12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,378,400.00</b>	<b>37,828,932.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,464,400.00	2,479,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,464,400.00	2,479,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,464,400.00	2,479,000.00
121	Хөрөнгийн орлого	4,914,000.00	35,349,932.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	4,914,000.00	35,349,932.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>16,747,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	279,724,200.00	283,509,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,747,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	247,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	15,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	15,000,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>315,162,360.41</b>	<b>331,114,199.50</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>315,162,360.41</b>	<b>331,114,199.50</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>297,223,403.04</b>	<b>330,042,142.50</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,760,696.40	208,505,900.00
210101	Үндсэн цалин	152,006,562.40	184,342,795.00
210102	Нэмэгдэл	6,792,346.00	6,615,480.00
210104	Урамшуулал	16,961,788.00	17,547,625.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,171,200.23	26,063,400.00
210201	Тэтгэврийн даатгал	14,114,200.23	17,723,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,550,199.92	2,085,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,625,500.28	1,668,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352,900.25	417,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,528,399.55	4,170,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,060,046.00	12,917,565.00
210301	Гэрэл, цахилгаан	2,035,375.00	1,844,806.00
210302	Түлш, халаалт	5,014,252.00	7,128,540.00
210303	Цэвэр, бохир ус	4,010,419.00	3,944,219.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,484,903.83	2,337,682.02
210401	Бичиг хэрэг	391,630.00	527,350.00
210402	Тээвэр, шатахуун	249,050.00	201,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	472,500.00	477,190.00
210404	Ном, хэвлэл	00.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,371,723.83	684,160.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	317,882.02
2105	Нормативт зардал	48,598,500.00	44,858,378.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	27,000.00
210502	Хоол, хүнс	48,448,500.00	44,731,378.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,153,600.00	1,287,000.00
210604	Урсгал засвар	1,153,600.00	1,287,000.00
2107	Томилолт, зочны зардал	92,000.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	92,000.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	810,000.00	402,400.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,000.00	222,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,092,456.58	33,571,817.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,900.00	260,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,461,556.58	33,011,817.48
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,938,957.37	1,072,057.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,814,700.00	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,700,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,814,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,257.37	872,057.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,257.37	872,057.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-29,059,760.41	6,971,532.50
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,806,166.89	365,335.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,806,166.89	365,335.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,806,166.89	-365,335.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-36,865,927.30	6,606,197.22

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	279,724,200.00	300,256,800.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	279,724,200.00	300,256,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	279,724,200.00	283,509,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,747,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	247,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	15,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	15,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	279,724,200.00	300,256,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	279,724,200.00	300,256,800.00

210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>261,785,242.63</b>	<b>299,184,743.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,310,796.63	208,506,900.00
210101	Үндсэн цалин	152,556,662.63	184,342,795.00
210102	Нэмэгдэл	6,792,346.00	6,616,480.00
210104	Урамшуулал	16,961,788.00	17,547,625.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,171,200.00	26,063,400.00
210201	Тэтгэврийн даатгал	14,114,200.00	17,723,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,550,200.00	2,085,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,625,500.00	1,668,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352,900.00	417,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,528,400.00	4,170,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,060,046.00	12,917,565.00
210301	Гэрэл, цахилгаан	2,035,375.00	1,844,806.00
210302	Түлш, халаалт	5,014,252.00	7,128,540.00
210303	Цэвэр, бохир ус	4,010,419.00	3,944,219.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,522,500.00	2,397,500.00
210401	Бичиг хэрэг	334,030.00	667,350.00
210402	Тээвэр, шатахуун	249,050.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	472,500.00	477,190.00
210404	Ном, хэвлэл	56,000.00	102,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	410,920.00	850,460.00
2105	Нормативт зардал	48,763,100.00	44,921,378.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	90,000.00
210502	Хоол, хүнс	48,448,500.00	44,731,378.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	164,600.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,353,600.00	2,800,000.00
210604	Урсгал засвар	1,353,600.00	2,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	92,000.00	98,000.00
210702	Дотоод албан томилолт	92,000.00	98,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	812,000.00	680,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,000.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	500,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,938,957.37</b>	<b>1,072,057.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,814,700.00	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,700,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,814,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	200,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,257.37	872,057.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,257.37	872,057.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,445,232.20	101,377,599.00	1,219,104,055.36	1,442,926,886.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,445,232.20	101,377,599.00	1,219,104,055.36	1,442,926,886.56
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,606,197.22	6,606,197.22
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,445,232.20	101,377,599.00	1,225,710,252.58	1,449,533,083.78

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны
----------	-------------

	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	298,509,300.00	297,637,243.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	298,509,300.00	297,637,243.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	298,309,300.00	297,437,243.00
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	208,506,900.00	208,506,900.00
Үндсэн цалин	184,296,200.00	184,342,795.00
Нэмэгдэл	6,756,700.00	6,616,480.00
Урамшуулал	17,454,000.00	17,547,625.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,063,400.00	26,063,400.00
Тэтгэврийн даатгал	17,723,000.00	17,723,000.00
Тэтгэмжийн даатгал	2,085,100.00	2,085,100.00
ҮОМШӨ-ний даатгал	1,668,100.00	1,668,100.00
Ажилгүйдлийн даатгал	417,100.00	417,100.00
Эрүүл мэндийн даатгал	4,170,100.00	4,170,100.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,700,000.00	12,917,565.00
Гэрэл, цахилгаан	1,900,000.00	1,844,806.00
Түлш, халаалт	7,500,000.00	7,128,540.00
Цэвэр, бохир ус	4,300,000.00	3,944,219.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,150,000.00	2,150,000.00
Бичиг хэрэг	300,000.00	449,850.00
Тээвэр, шатахуун	250,000.00	200,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	457,000.00	477,190.00
Ном, хэвлэл	250,000.00	72,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	100,100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	793,000.00	850,460.00
<b>Нормативт зардал</b>	45,009,000.00	44,921,378.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,000.00	90,000.00
Хоол, хүнс	44,819,000.00	44,731,378.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,300,000.00	1,300,000.00
Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	100,000.00	98,000.00
Дотоод албан томилолт	100,000.00	98,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	680,000.00	680,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	500,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	800000.00	800000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	200000.00	200000.00
Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	298,509,300.00	298,509,300.00
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	283,509,300.00	283,509,300.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	283,509,300.00	283,509,300.00
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	15,000,000.00	15,000,000.00



Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн төсвөөс	15,000,000.00	15,000,000.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00